



МОНГОЛБАНКНЫ  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2012 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А-69

Улаанбаатар хот

Төгрөгийн нэрлэсэн ба бодит үйлчилж буй ханшийн  
индексийг тооцох аргачлалыг батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Төгрөгийн нэрлэсэн ба бодит үйлчилж буй ханшийн индексийг тооцох аргачлал”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллан, “Төгрөгийн нэрлэсэн болон бодит үйлчилж буй ханшийн индекс”-ийг сар бүр тооцож Мөнгөний бодлого, судалгааны газар (Д.Болдбаатар)-т хүргүүлж байхыг Валют, эдийн засгийн газар (Д.Дэлгэрсайхан)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Г.Тогтохбаатар)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Л.ПҮРЭВДОРЖ

Монголбанкны Ерөнхийлөгчийн  
2012 оны 6-дугаар сарын 9-ны  
өдрийн 4.69 дугаар тушаалын хавсралт

**ТӨГРӨГИЙН НЭРЛЭСЭН БА БОДИТ ҮЙЛЧИЛЖ БУЙ  
ХАНШИЙН ИНДЕКСИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ**

**НЭГ. Аргачлалын зорилго**

- 1.1. Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн индексийг Монгол Улсын гадаад худалдааны гол түнш орнуудын худалдааны хэмжээ /экспорт, импорт/, үнэ, ханшийн өөрчлөлттэй уялдуулан тооцож, төгрөгийн бодит худалдан авах чадварыг тодорхойлоход энэхүү аргачлалын зорилго оршино.

**ХОЁР. Нэр томъёо**

- 2.1. **Валютын ханш** гэж үндэсний мөнгөн тэмдэгтийн бусад валюттай харьцах үнийг хэлнэ. Валютын ханшийг нэрлэсэн ба бодит гэж ангилдаг. Нэрлэсэн ханш гэж гадаад орны мөнгөн тэмдэгттэй харьцах үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийг, бодит ханш гэж нэрлэсэн ханшаас үнийн нөлөөг хасч тооцсон ханшийг хэлнэ.
- 2.2. **Валютын ханшийн индекс** нь суурь болгон авч үзсэн хугацаа /суурь хугацаа/-н дахь валютын ханштай харьцуулахад тайлант хугацаанд валютын /нэрлэсэн ба бодит/ ханш хэрхэн өөрчлөгдсөнийг харуулна.
- 2.3. **Худалдааны түнш орнууд** гэж манай улсын нийт экспорт, импорт, гадаад худалдааны эргэлтэнд дийлэнх хувийг эзэлж буй орнуудыг хэлнэ.
- 2.4. **Үйлчилж буй ханшийн индекс /Effective exchange rate/** гэж гадаад худалдааны түнш орнуудын валюттай харьцах үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийн индексийн жигнэсэн дундаж нэгжтэй харьцуулсан үндэсний мөнгөн тэмдэгтийн үнийг хэлнэ. Үйлчилж буй ханшийг нэрлэсэн ба бодит үйлчилж буй ханш гэж ангилна.
- 2.5. **Нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс /Nominal effective exchange rate/** гэж гадаад худалдааны түнш орнуудын валюттай харьцах үндэсний мөнгөн тэмдэгтийн нэрлэсэн ханшийн индексүүдийн жигнэсэн дундаж нэгжтэй харьцуулсан үндэсний мөнгөн тэмдэгтийн үнийг хэлнэ. Нэрлэсэн үйлчилж буй ханшийн индексийг NEER гэж тэмдэглэнэ.
- 2.6. **Бодит үйлчилж буй ханшийн индекс /Real effective exchange rate/** гэж гадаад худалдааны түнш орнуудын валюттай харьцах үндэсний мөнгөн тэмдэгтийн бодит ханшийн индексүүдийн жигнэсэн дундаж нэгжтэй харьцуулсан үндэсний мөнгөн тэмдэгтийн үнийг хэлнэ. Бодит үйлчилж буй ханшийн индексийг REER гэж тэмдэглэнэ.
- 2.7. **Үйлчилж буй ханшийн индекс тооцох хувийн жин** гэж гадаад худалдааны тухайн нэг түнш орны валюттай харьцах үндэсний мөнгөн тэмдэгтийн /нэрлэсэн ба бодит/ ханшийн индексэд харгалзуулж буй ач холбогдлын түвшинг хэлнэ.

- 2.8 Үйлчилж буй ханшийн индекс тооцох суурь хугацаа** гэдэгт тайлант хугацаанаас хоёр жилийн өмнөх оны 12 дугаар сарыг ойлгоно. Жишээ нь: 2012 оны 1 дүгээр сарын тухайд 2010 оны 12 дугаар сарыг суурь хугацаа гэнэ.
- 2.9 Үнийн индекс** гэж тухайн нэг улсын 2005 оны 12 дугаар сарын суурьтай хэрэглээний үнийн индексийг хэлнэ.

**ГУРАВ. Төгрөгийн нэрлэсэн ба бодит үйлчилж буй ханшийн индексийг тооцох аргачлал**

- 3.1 Төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханшийн индексийг** дараах томъёогоор тооцно:

$$NEER_{i,t} = \prod_{i=1}^n S_{i,t}^{*w_{i,y-2/12}} * NEER_{y-2/12} \quad (1)$$

$n$  ~ худалдааны түнш орнуудын тоо

$i$  ~ худалдааны түнш орны дугаар

$S_{i,t}^*$  ~  $t$  хугацааны эцэст  $i$ -р худалдааны түнш орны валюттай харьцах төгрөгийн нэрлэсэн ханшийн индекс

$y$  ~ индекс тооцож буй жилийн дугаар

$(y - 2/12)$  ~ суурь хугацаа

$w_{i,y-2}$  ~ суурь хугацаанд тооцсон  $i$ -р орны валютад харгалзах хувийн жин

- 3.1.1.  $t$  хугацааны эцэст  $i$ -р худалдааны түнш орны валюттай харьцах төгрөгийн нэрлэсэн ханшийн индексийг** дараах томъёогоор тооцно:

$$S_{i,t}^* = \frac{S_{i,t}}{S_{i,y-2/12}}; \quad S_{i,t} = \frac{1}{E_{\frac{USD}{MNT},t} * E_{i,USD,t}} \quad (2)$$

$S_{i,t}$  ~  $t$  хугацааны эцэст  $i$ -р улсын валюттай харьцах төгрөгийн нэрлэсэн ханш

$S_{i,y-2/12}$  ~ суурь хугацааны эцэст  $i$ -р улсын валюттай харьцах төгрөгийн нэрлэсэн ханш

$E_{\frac{USD}{MNT},t}$  ~  $t$  хугацааны эцэст төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан, сарын дундаж ханш

$E_{i,USD,t}$  ~  $t$  хугацааны эцэст ам.доллартай харьцах  $i$  -р орны валютын сарын дундаж, нэрлэсэн ханш (кросс ханш)

- 3.1.2.** Худалдааны түнш орны валютад харгалзах хувийн жинг жилд нэг удаа, жил бүрийн 1 дүгээр сард шинэчлэн тооцож индексийн тооцоонд ашиглана.

- 3.2. Төгрөгийн бодит үйлчилж буй ханшийн индексийг** дараах томъёогоор тооцно:

$$REER_{i,t} = \prod_{i=1}^n \left( \frac{S_{i,t}^*}{P_{i,t}^*} \right)^{w_{i,y-2/12}} * REER_{y-2/12} \quad (3)$$

$P_{i,t}^*$  ~  $t$  хугацааны эцэст  $i$ -р орны үнийн индексийг дотоодын үнийн индексэд харьцуулсан харьцаа

- 3.3. Худалдааны түнш орны валютад харгалзах хувийн жинг** дараах томъёогоор тооцно:

$$w_{i,t} = \alpha_{1,t} * [(1 - \alpha) * \varepsilon_{i,t} + \alpha * \tau_{i,t}] + \alpha_{2,t} * \mu_{mon,i,t} \quad (4)$$

$\varepsilon_{i,t} \sim t$  хугацааны эцэст Монгол Улсаас i-р орон руу хийх экспортын Монгол Улсын нийт экспортод эзлэх хувь

$\tau_{i,t} \sim t$  хугацааны эцэст Монгол Улс болон i-р орноос гуравдагч зах зээлд хийх экспортын өрсөлдөөний түвшинг харуулах үзүүлэлт

$\mu_{mon,i,t} \sim t$  хугацааны эцэст i-р орноос Монгол Улс руу хийх экспортын Монгол Улсын нийт импортод эзлэх хувь

$\alpha_{1,t} \sim t$  хугацааны эцэст Монгол Улсын экспортын жингийн нийт жин дэх ач холбогдлын түвшин

$\alpha_{2,t} \sim t$  хугацааны эцэст Монгол Улсын импортын жингийн нийт жин дэх ач холбогдлын түвшин

$\alpha \sim$  Монгол Улс болон i-р орноос гуравдагч зах зээлд хийх экспортын өрсөлдөөний түвшинд харгалзуулах ач холбогдлын түвшин

3.3.1.  $t$  хугацааны эцэст Монгол Улсаас i-р орон руу хийх экспортын Монгол Улсын нийт экспортод эзлэх хувийг дараах томъёогоор тооцно:

$$\varepsilon_{i,t} = \frac{x_{i,t}}{\sum_{i=1}^n x_{i,t}} \quad (5)$$

$x_{i,t} \sim t$  хугацааны эцэст Монгол Улсаас i-р орон руу хийх экспортын хэмжээ

3.3.2.  $t$  хугацааны эцэст Монгол Улс болон i-р орноос гуравдагч зах зээлд хийх экспортын өрсөлдөөний түвшинг дараах томъёогоор тооцно:

$$\tau_{i,t} = \sum_{k \neq i, mon}^n \frac{\varepsilon_{i,t} * \mu_{k,i,t}}{(1 - \mu_{k,mon,t})} \quad (6)$$

$k \sim$  i-р орноос бусад, Монгол Улсын худалдааны түнш орны дугаар

$\mu_{k,mon,t}, \mu_{k,i,t}$  нь харгалзан  $t$  хугацааны эцэст Монгол болон i-р орноос k-р орон руу хийх экспортын k-р орны нийт импортод эзлэх хувь

3.3.3.  $t$  хугацааны эцэст i-р орноос Монгол Улс руу хийх экспортын Монгол Улсын нийт импортод эзлэх хувийг дараах томъёогоор тооцно.

$$\mu_{mon,i,t} = \frac{m_{i,t}}{\sum_{i=1}^n m_{mon,i,t}} \quad (7)$$

$m_{i,t} \sim t$  хугацааны эцэст Монгол улсын i-р орноос авах импортын хэмжээ

3.3.4.  $t$  хугацааны эцэст Монгол Улсын экспортын жингийн нийт жин дэх ач холбогдлын түвшинг дараах томъёогоор тооцно.

$$\alpha_{1,t} = \frac{\sum_{i=1}^n x_{i,t}}{\sum_{i=1}^n (x_{i,t} + m_{i,t})} \quad (8)$$

3.3.5.  $t$  хугацааны эцэст Монгол Улсын импортын жингийн нийт жин дэх ач холбогдлын түвшинг дараах томъёогоор тооцно.

$$\alpha_{2,t} = \frac{\sum_{i=1}^n m_{i,t}}{\sum_{i=1}^n (x_{i,t} + m_{i,t})} \quad (9)$$

**ДӨРӨВ. Төгрөгийн нэрлэсэн ба бодит үйлчилж буй ханшийн индексийг тооцоход ашиглах статистик мэдээлэл, эх сурвалж**

- 4.1. Энэхүү аргачлалын 3.1, 3.2, 3.3-т дурдсан худалдааны түнш орон гэдэгт Монгол Улсын экспорт, импорт, гадаад худалдааны нийт эргэлтэд дийлэнх хувийг эзэлж буй орнуудыг хамруулна.
- 4.2. Энэхүү аргачлалын 3.1.1-д дурдсан  $t$  хугацааны эцэст  $i$ -р орны валютын ам.доллартай харьцах сарын дундаж, нэрлэсэн ханшийг Блүмберг терминалын өдөр бүрийн хаалтын спот ханшийн дунджаар тооцно.
- 4.3. Энэхүү аргачлалын 3.2-т дурдсан түнш орнуудын хэрэглээний үнийн индексийг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын цахим хуудас болон гадаад орнуудын төвбанк, статистикийн төв байгууллагын цахим хуудаснаас сар бүр авч ашиглана. Монгол Улсын хувьд Монголбанкны сар бүрийн статистикийн бюллетенийг ашиглана.
- 4.4. Энэхүү аргачлалын 3.3.1, 3.3.3, 3.3.4-т дурдсан Монгол Улсын экспорт, импортын статистикийг Монгол Улсын Гаалийн ерөнхий газраас гаргадаг “Гадаад худалдааны статистик мэдээлэл”-ээс авч ашиглана.
- 4.5. Энэхүү аргачлалын 3.3.2-т дурдсан түнш орнуудын жил бүрийн импортын статистик мэдээллийг НҮБ-аас гаргадаг гадаад худалдааны статистикаас авч ашиглана.

**ТАВ. Төгрөгийн нэрлэсэн ба бодит үйлчилж буй ханшийн индексийг тооцож, олон нийтэд мэдээлэх**

- 5.1. Валют, эдийн засгийн газар нь төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханшийн индексийг нэг сарын хоцрогдолтойгоор, төгрөгийн бодит үйлчилж буй ханшийн индексийг хоёр сарын хоцрогдолтойгоор, сар бүрийн 15-ны өдрөөс өмнө тооцож Мөнгөний бодлого, судалгааны газарт цахим шуудангаар хүргүүлнэ.

5.2. Мөнгөний бодлого, судалгааны газар нь төгрөгийн нэрлэсэн ба бодит үйлчилж буй ханшийн индексийг Монголбанкны тухайн сарын статистикийн бюллетенд оруулж, нийтэд мэдээлж байна.

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_